



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-11
<hr/>	
1. “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, үргэлжлэв/	5-6
2. Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	6-11

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
04 дүгээр сарын 11-ний өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 64 гишүүн хүрэлцэн ирж, 50.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: М.Бадамсүрэн, Х.Булгантуяа, Г.Ганбаатар, С.Лүндээ, Ц.Мөнхбат, Л.Мөнхбаясгалан, Б.Найдалаа, Н.Наранбаатар, О.Номинчимэг, Б.Пунсалмаа, О.Саранчулуун, Л.Соронзонболд, Р.Сэддорж, Ч.Ундрэм;

Чөлөөтэй: П.Батчимэг, А.Ганбаатар, П.Ганзориг, Л.Оюун-Эрдэнэ, Д.Үүрийнтуяа, Д.Энхтүвшин;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Амарсайхан, Э.Бат-Амгалан, Ж.Баярмаа, Ж.Ганбаатар, Б.Заяабал, Т.Мөнхсайхан, П.Мөнхтулга, Б.Чойжилсүрэн;

Тасалсан: Ж.Батсуурь, Х.Баттулга, Д.Ганбат, Т.Доржханд, З.Мэндсайхан, С.Одонтуяа, Д.Пүрэвдаваа, Н.Учрал, Ж.Энхбаяр;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан -10 минут, Н.Алтанхуяа -20 минут, Б.Батбаатар -02 минут, Д.Батлут -05 минут, Б.Батцэцэг -08 минут, Э.Батшугар -10 минут, Ж.Бат-Эрдэнэ -02 минут, Ж.Баясгалан -01 минут, Х.Болормаа -01 минут, Ш.Бямбасүрэн -16 минут, Ж.Галбадрах -11 минут, С.Ганбаатар -08 минут, Л.Гантөмөр -18 минут, Г.Дамдинням -03 минут, Б.Дэлгэрсайхан -08 минут, Б.Жавхлан -05 минут, Х.Жангабыл -05 минут, Б.Жаргалан -04 минут, Ч.Лодойсамбуу -17 минут, Ц.Мөнхтуяа -22 минут, М.Нарантуяа-Нара -03 минут, А.Ундраа -04 минут, С.Эрдэнэбат -01 минут.

Нэг. “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, үргэлжлэв/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

“Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг эцэслэн батлах санал хураалтаар үргэлжлэв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	53
Татгалзсан:	18
Бүгд:	71

74.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын нийт гишүүний олонх соёрхон батлах тухай хуулийн төслийг батлахыг дэмжээгүй тул “Хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Уг асуудлыг 10 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ж.Түвшинжаргал, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Б.Уянга нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар, хуулийн төсөл санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг нар хариулж, тайлбар хийв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооноос гаргасан Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71

Татгалзсан: 16

Бүгд: 87

81.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71

Татгалзсан: 17

Бүгд: 88

80.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалттай холбоотой мэдээлэл хийв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 23 минут үргэлжилж, 126 гишүүнээс 89 гишүүн хүрэлцэн ирж, 70.6 хувийн ирцтэйгээр 10 цаг 23 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 00 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдэд энэ өглөөний амар амгаланг айлтгаж мэндчилье. 2025 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сарын 11-ний өдрийн чуулганы хуралдааны ирц хүрсэн тул чуулганы хуралдааныг нээснийг мэдэгдье.

Өнөөдөр чуулганы нэгдсэн хуралдааны үдээс өмнөх хуралдаанаар 2 асуудлыг хэлэлцэнэ. 1 дүгээрт, Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай санал хураалтыг үргэлжлүүлэн явуулна. 2 дугаарт, Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Нэг. “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, үргэлжлэв/

Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцүүлнэ. Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан. Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулахаар байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан байгаа. Дэлгэрсайхан сайд өөрөө хаачсан юм бэ?

Байнгын хорооны саналаар Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай хэлэлцээрийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Нийт гишүүдийн олонх буюу 64 гишүүнээр асуудал дэмжигдэх ёстой гэдгийг гишүүд анхааралдаа авахыг хүсье. Ингээд санал хураалт явуулъя. Санал хураалт. 53 гишүүн буюу асуудал дэмжигдсэнгүй. Хуулийн төслийг буцаах тогтоол аваад ир дээ, буцаана. Буцаах тогтоол аваад ир.

Хуулийн төсөл буцаах тухай. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 79.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь: Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Транс-Азийн төмөр

замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул хууль санаачлагчид төслийг буцаасан.

10.04 цаг

Хоёр.Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Өмгөөллийн тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Уянгахишигээс 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хийж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороонд шилжүүлсэн билээ.

ХЗБХ 2025 оны 04 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцсэн болно. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг хуулийн төслийн дагаж мөрдөх хугацааны талаар асуулт асууж, хариулт авлаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Байнгын хорооны гишүүдээс зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн, ХЗБХ-ны дарга Цогтбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24 дэх хэсэгт заасныг баримтлан хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 71,4 хувийн саналаар дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэгт харьяалагддаг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэболд: Баярлалаа. Энэ 2022 оны Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргасан байгаа. 8 дугаар зүйлийн 8.3, 8.6.3 дахь заалт Үндсэн хуульд заасан ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийг хязгаарласан байх магадлалтай гэсэн ийм зүйл гаргасан байгаа. Би зарчмын хувьд энэ хуулийн өөрчлөлтийг дэмжиж байгаа. Тэгээд яах вэ гол үндэслэл нь нөгөө Үндсэн хуулийн ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрх нь хязгаарлагдсан байж болзошгүй гэсэн 1 дүгээрт дүгнэлт байна.

2 дугаарт нь Өмгөөлөгчдийн холбоо дээр ирүүлсэн 400 гаруй хүнээс шалгалтад орохоор ирүүлснээс 40 гаруй хүн хасагдаад, тэдгээрийн дийлэнх нь гомдол гаргаад явсан. Мэдээж шалгалтад орохын тулд ажлаас гарах болдог, давхар ажил эрхэлж болохгүй байгаа учраас ажлаас гараад шалгалтдаа тэнцэхгүй бол ажилгүй болчихдог ийм нөхцөл байдал байгаад байгаа. Тэгэхээр бол мэдээж их сургуульд багшлах ч гэдэг юм уу, эрдэм шинжилгээний ажил хийгээд явангаа өмгөөллийн ажил хийхийг хуулиар зөвшөөрч байгаа. Гэхдээ яах вэ нөгөө улс төрийн болон бусад ажлыг хориглож байгаа. Ер нь зарчмын хувьд хуулийн үзэл баримтлалыг дэмжиж байгаа.

Нэг асуулт нь болохлоороо зөвхөн энэ 8.6.3 дахь заалтаас гадна ер нь энэ Өмгөөллийн хуулийг цогцоор нь шинэчлэх, өөрчлөх бусад олон асуудлуудыг хамт оруулж ирэхгүй байсан уу? Ер нь цаашид ийм Уянгахишиг гишүүнээс асууж байгаа нь цаашид ийм шаардлагууд байгаа юу? Тухайлбал зарим төрлийн гэмт хэрэг дээр өмгөөллийн үйл ажиллагаа хийж хамгаалж явж байгаад сүүлдээ өөрөө гэмт хэрэгтэн болох тохиолдол маш их байгаад байдаг. Сүүлдээ өөрөө ялтан болоод шоронд орчихсон тохиолдлууд ч гэсэн байгаад байгаа юм. Цаад утгаараа өмгөөлөгчийн эрх болон энэ өмгөөлөх процесс чинь өөрөө хэр зэрэг хуулийн хамгаалалтад байна вэ? Энэ 8.6.3-ыг цуцлахыг хүчингүй болгохыг дэмжиж байгаа. Гэхдээ нөгөө талаасаа энэ өмгөөлөлтэй холбоотой эко систем буюу шударга ёсыг сахиулах хэргийн процесст өмгөөлөгчийн эрх хэр хангагдаж байгаа юм бэ? Тэгээд энэ дээр ер нь хуулийнхаа энэ том агуулгад нь хэр зэрэг хяналт хийсэн юм бэ, судалгаа шинжилгээ хийсэн юм бэ? Энэ чиглэлээр ер нь дараа нь дахиад Өмгөөллийн хуультай холбоотой өөр ийм асуудлууд орж ирэх юм уу? Энэ дээр нэг хариулт авъя гэж бодож байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хууль санаачлагч Уянгахишиг гишүүн асуултад хариулья.

Г.Уянгахишиг: Эрдэнэболд гишүүний асууж байгаа асуулт яг яалт ч үгүй тулгамдаад байгаа асуудал мөн. Эхний ээлжид яг энэ Өмгөөллийн тухай хуулийн 8.6.3 бол шалгалтад орох гэж байгаа хуульчдын хувьд эрх зүйн байдлыг дордуулсан гэдэг агуулгаараа зөвхөн энэ заалтаа авч орж ирээд хэлэлцүүлээд явж байгаа. Энэнээс цаашаагаа ер нь Өмгөөллийн хуулиа эргэж харах ёстой юм байна гэдэг асуудлууд маш их хөндөгдөж байгаа. Ялангуяа хамгийн ойрхон гээд ярихад яг энэ ажил хөдөлмөр давхар эрхлэлт гэдэг дээр жишээлбэл энэ 15.1.13 дээр улс төрийн нам, түүний харьяа салбар бүтцийн нэгжид орон тооны ажил албан тушаал хавсран эрхлэх гэж байгаа байхгүй юу. Гэтэл өмгөөлөгчийн, өмгөөлөгч гэдэг маань өөрөө улс төрийн албан тушаалтан ч юм уу тийм ээ яг улс төртэй хамааралтай ажил албан тушаал биш. Нөгөө талаасаа компанийн хуульч өмгөөлөгч хийхийг хориглоно гэдэг заалттай болчхож байгаа юм. Өөрөөр хэлбэл нөгөө давхар ажил хөдөлмөр эрхэлж болохгүй гэдгээрээ. Тэгэхээрээ энэ ер нь

давхар ажил хөдөлмөр эрхэлж болохгүй гэдэг энэ заалтуудыг ч гэсэн ер нь авч үзэх ёстой.

Нөгөө талаасаа өмгөөлөгчийн хувьд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн дагуу болон яг мөрдөн шалгах ажиллагаа дээр өмгөөлөгч прокурортой эн тэнцүү орж чадаж байгаа юу? Яг тухайн нотлох баримт цуглуулах дээр, буцаад тэр материалуудтай, нотлох баримтуудтай, мөрдөн шалгах ажиллагааны явцад цуглуулсан баримтуудтай танилцах, мөн түүнчлэн тухайн мөрдөн шалгах ажиллагааны явцад нотлох баримт цуглуулах дээр, мөн өмгөөлөгчийг хамгаалах тал дээр гэх мэтчилэн нэлээн олон ажлууд, нэлээн олон асуудлуудыг зохицуулах шаардлагатай байгаа. Энэ утгаараа цаашид энэ Өмгөөллийн хууль дээрээ үргэлжлүүлээд ажиллана. Тэгээд энэ дээр Эрдэнэболд гишүүн ч гэсэн хамтраад ажиллах байх гэж харж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Болдын Уянга гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Уянга: Энэ Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалтыг хүчингүй болгоё гээд хууль санаачлагчаас орж ирж байна. Гэхдээ яг энийг судлаад үзэхээр 2022 оны 02 дугаар тогтоол Үндсэн хуулийн цэц дээр яг энэ 8.6.3 дахь заалт бол Үндсэн хууль зөрчөөгүй юм гэсэн дүгнэлт Дунд суудлын хуралдаан дээр гарсан юм байна. Та тэрийгээ сайн мэдэж байгаа байх. Тухайн үед 2022 онд Улсын Их Хурлаас төлөөлөөд Мөнх-Оргил гишүүн очиж оролцсон байна лээ. Тэгээд дунд суудлын хуралдаанаас Үндсэн хуулийг зөрчөөгүй гэсэн дүгнэлт нь гараад, тэгээд энэ 2024 оны 09 сарын 04-нд Их суудал яг энэ асуудлыг авч хэлэлцэнэ гээд тогтчихсон байгаад, Их суудлын хуралдааныг хүлээж байх явцад Улсын Их Хурлын гишүүд бид энэ зүйл, заалтыг нь аваад хаячхаж болох юм уу? Миний ойлголтоор Үндсэн хуулийн цэцэд л Монгол Улсын хамгийн шилдэг хуульчид байх ёстой. Тэгэхээр тэд нарынхаа ядаж энэ хуулийн Үндсэн хууль яг зөрчсөн эсэх тэр дүгнэлтийг нь эцэслэн авахыг хүлээх ёстой гэж бодоод байх юм. Энэ дээр та нэг хариултаа өгнө үү?

Яг энэ 2022 оны 2 дугаар энэ Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны яг энэ тэмдэглэлийг нь уншаад үзэхэд 8.6.3 дахь заалтыг боловсронгуй болгох нь зүйтэй байдлаар Мөнх-Оргил гишүүн ч гэсэн өөрөө тэмдэглэж үлдээсэн байна лээ. Тэгэхээр энэ даалгавраа хийгээд, 8.6.3 дахь заалтыг боловсронгуй л болгох ёстой юм биш үү? Яагаад та заавал Их суудал хуралдахаас өмнө энэ заалтыг бүүр аваад хаячихъя гэж үзэж байгаа юм бол? Энэ дээр хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Уянгахишиг гишүүн асуултад хариулъя.

Г.Уянгахишиг: Яг энэ тухайн Өмгөөллийн тухай хуулийн 8.6.3 өөрөө нэлээн олон жил асуудал дагуулж байгаа заалт. Яагаад гэвэл энэний цаана яг хуульчдын би ч гэсэн өөрөө өмгөөлөгч хийж байсан. Тэгээд хуульчдын хувьд энэ өөрөө яг өмгөөллөөр үйл ажиллагаа явуулъя гэж байгаа хуульчдын хувьд байнгын хүндрэл учруулдаг, шалгалтад орох боломжгүй байдлыг үүсгэдэг ийм заалт байгаад байгаа юм. Тэгэхээр хууль тогтоох байгууллагын хувьд Улсын Их Хурлын хувьд өөрөө хуулиа засах боломж нь бий. Энийг 22 оны яг энэ Үндсэн хуулийн цэцийн хуралдаан дээр ч гэсэн Мөнх-Оргил гишүүний зүгээс итгэмжлэгдсэн төлөөлөгчийн зүгээс Их Хурал өөрөө засах боломжтой юм гэдгийг яг дурдаж хэлсэн байдаг. Энэ

утгаараа Их Хурал өөрөө гишүүдийн зүгээс санаачлаад энэ хуулийн заалтыг хүчингүй болгох энэ боломж нь байгаа. Ингэснээрээ хэрэв яг маргааны гол зүйл болж байгаа энэ заалт маань хүчингүй болчихвол Үндсэн хуулийн цэц дээрх маргаан үргэлжлэхгүйгээр зогсох боломжтой гэсэн үг.

Үндсэн хуулийн их хуралдаанаар, Үндсэн хуулийн цэцийн Их суудлын хуралдаанаар хэрэг үүсгэсэн шалтгаан 22, ер нь яг өмнө нь шийдвэрлэсэн асуудлаар Цэц дээр маргаан дахиж үүсгэдэггүй болов чиг яг энэ тохиолдолд дахиж үүсгэсэн байгаа буюу энэ нь өөрөө энэ заалт маань Үндсэн хууль зөрччихсөн байх магадлал өндөр байна гэдэг энэ асуудал яригдчихсан байгаад байгаа юм. Тийм учраас заавал Цэцээс хүчингүй болгуулах гэхээс илүүтэйгээр Улсын Их Хурал өөрөө буруу байгаа заалтуудаа өөрсдөө засаад явбал яагаад болдоггүй юм бэ гэдэг энэ хувилбараар энэ хуулийн төслийг өргөн бариад явж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Болдын Уянга гишүүн тодруулж асууя.

Б.Уянга: Тэгвэл арай өөрөөр асууя. 22 оны энэ 02 дугаар Үндсэн хуулийн цэцийн Дунд суудлын хуралдаанаар Үндсэн хуулийг зөрчөөгүй гээд дүгнэчихсэн байгаа байхгүй юу. Тэгэнгүүт та Үндсэн хуулийг зөрчсөн байна ер нь бүүр хасаад хаячихъя гээд байх юм. Зүгээр хэрвээ 8.6.3-ыг хүчингүй болгохгүйгээр сайжруулан боловсруулъя гэсэн танд санал байна уу?

Д.Амарбаясгалан: Уянга гишүүн энэ ийм юм байна лээ. Өмгөөлөгчийн шалгалт өгөх хүн өмгөөлөгчөөр ажиллахад харшлах албан тушаалаа заавал өгч байж шалгалтаа өгнө гэдэг заалт орж ирчхээд байгаа байхгүй юу. Тэгээд энэ чинь өөрөө тэр шалгалтад ороод ямар үр дүн гарах нь тодорхойгүй байхад эрхэлж байгаа ажил албан тушаалаасаа чөлөөлөгдчихөөд, шалгалтад орно гэдэг нь өөрөө хүний эрхийн зөрчил үүсгэж байна гэж үзсэн. Тийм учраас энэ заалтыг Уянгахишиг гишүүн нэмэлт, өөрчлөлтөөр байхгүй болгоё гэдэг санал орж ирж байгаа юм. Дөнгөж түрүүчийн долоо хоногт бид шүүгчийн насны хязгаартай холбоотой асуудал Үндсэн хуулийн цэцээс Үндсэн хууль зөрчсөн байна гэдэг дүгнэлт гарсныг Улсын Их Хурал хүлээж авч байгаа юм.

Тэгэхээр ер нь ганц энэ Өмгөөллийн тухай хууль гэлтгүй өчигдөр бидний хэлэлцээд баталсан Прокурорын тухай хууль, Шүүхийн тухай хууль, энэ Өмгөөлөгчийн тухай хууль гээд салбарын зохицуулалт хийж байгаа хуулиудаар хүний эрхийн зөрчил үүсгэж болзошгүй ийм заалтууд байна гэж үзэж байгаа. Тэгээд эдгээр асуудлуудыг Тамгын газар дээр Хуулийн хэлтэс кодификацийн тасаг бол энийг бүртгэж байгаа. Сардаа нэг удаа ийм хүний эрхийн зөрчил үүсгэж байгаа Улсын Их Хурлын чуулган дээр яригдсан, гишүүдээс болон Байнгын хороодоос хөндөгдсөн асуудлуудыг тэмдэглээд, сардаа нэг удаа энэ зөрчлүүдийг арилгах алхмуудыг Улсын Их Хурал өөрийн санаачилгаараа хийе гэж байгаа юм. Тэгэхээр гишүүд ч гэсэн бусад салбарын хуулиудад үндсэн жишээ нь Төрийн албаны хуулиараа 65 насны хязгаар төрийн албаны дээд хязгаар байна гээд заачихсан байж байхад Шүүхийн хуулиараа 60 нас болгож аваачиж зохицуулаад л, Прокурорын хуулиараа 60 нас болгож аваачиж зохицуулаад байгаа нь өөрөө нийтлэг байдлаараа хүний эрхийг зөрчиж байна гэж үзэж байгаа учраас ийм зүйлүүдийг Улсын Их Хурал өөрсдийн санаачилгаар засъя л гэж байгаа юм. Тэрний нэг жишээ нь өнөөдөр энэ Өмгөөллийн хууль болж орж ирж байгаа гэдгийг хэлье. Дамдины Цогтбаатар гишүүн энэ дээр хариулт өгье.

Д.Цогтбаатар: Энд Их Хурлын гишүүд бид нэг зүйлийг ойлгох ёстой, нэг ойлголттой хэдүүлээ болж авах нь зөв гэж бодож байгаа. Сая ингээд асуулт бол Үндсэн хуулийн цэцээр хэлэлцэж байхад тэнд тэгэхлээр зөв гээд гарчихвал яах юм бэ гэж ярих гээд байх шиг байна л даа. Тэгэхлээр нэг юм энэ улсад хуулийг бид л тогтооно. Тэгээд илт энэ өөрөө зөрчилтэй байгаа бол бид энийг өөрчлөхөд Үндсэн хуулийн цэцэд хэлэлцэх асуудал өөрөө байхгүй болчхож байгаа юм. Бид зөрчилтэй байна гэж үзэж байгаа ямар ч хуулийг Үндсэн хуулийн цэцтэй, цэцгүй өөрөө шууд эндээ аваад, өөрчлөөд засаад явах эрхтэй тийм субъектүүд учраас энийг аягүй ойлгомжтой юмыг зөв гээд гарчихвал яана, зөв гээд гарчихвал бид буруу гэж үзээд, зөв гэсэн юмыг ч энэ зохисгүй заалт байна гэвэл бид өөрчлөх эрхтэй. Тэр өнцгөөсөө л бид энэ юунд хандаж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Цогтбаатар даргатай санал нэг байна. Тэгээд ер нь Үндсэн хуулийн цэцийн шийдвэр эцэслээд гарчихсан тохиолдолд тэр тухайн асуудлыг агуулгынх нь хүрээнд ахиж хөндөх боломжгүй болчихдог үр дагавар нь. Тэгэхээр энэ засаж болох зүйлийг бид энд нь эрт дээр нь засаж байна гэдэг бол Улсын Их Хурал үндсэн ажлаа хийж байна л гэж харах ёстой. Тэр талаасаа ингээд тайлбар өгчихье. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 71 гишүүн дэмжиж, 81,6 хувиар хуулийн төслийг эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх санал дэмжигдлээ. Тийм учраас Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна. Хуулийн төслийн эцэслэн батлуулах хувилбарыг ХЗБХ бэлдээд, гишүүдэд тараасан байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан. Тэгэхээр 64 гишүүнээр асуудал дэмжигдэх учиртай. Санал хураалт. Байнгын хорооны саналаар Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 71 гишүүн дэмжиж 80,7 хувиар санал дэмжигдлээ. Хуулийн төсөл батлагдлаа. Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт талархал дэвшүүлье.

10.21 цаг

Өнөөдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудал үүгээр дуусаж байгаа. Ер нь Улсын Их Хурал, гишүүд байж байгаарай. Би нэг товчхон мэдээлэл хийгээдэхье. Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх асуудлыг бид Дэгийн тухай хуулиар тодорхой цаг хугацаанд багтаж хэлэлцдэг. Улсын Их Хурлын гишүүд бүлэгт болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс асуух асуултын тоо тодорхой, хугацаа тодорхой болчихсон учраас чуулганыг маш тодорхой цаг хугацаанд товлож, хуралдуулдаг болно гэсэн ийм зарчмыг барьж байгаа.

Тухайлбал Пүрэв гарагийн чуулганы үдээс өмнөх хуралдаан яг хэлэлцэх асуудлын хугацаатай холбоотойгоор 10 цагт эхлээд 11 цагт юм уу, 11 цаг 30 минутад юм уу, 12 цагт өндөрлөх хугацаа тодорхой. Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаан нь үдээс хойшдоо эхлэх цаг нь тодорхой, дуусах цаг нь тодорхой байдлаар чуулганы хуралдааныг зарлаж, Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлөөс ингээд зохион байгуулдаг болж эхэлж байгаа юм.

Тийм учраас гишүүдэд тавих шаардлага юу байна вэ гэхээр тухайн асуудал өөрөө богино хугацаанд хэлэлцэгдэж байна. 1 цаг 30 минут, 2 цагийн хугацаанд хэлэлцэгдэж байна. Тэр асуудлыг хэлэлцэж байхад гишүүд бүрэн оролцоотой байх шаардлагыг Улсын Их Хурал талаас шаардлага тавьж ажиллана. Улсын Их Хурлын гишүүд асуулт асуух, үг хэлэхтэй холбоотойгоор нийтлэг байдлаараа нэрээ кнопоо дарчхаад гараад өөр давхар ажил амжуулаад явдаг байдал өмнө нь нийтлэг байсан. Цаашдаа бид ийм тодорхой цаг хугацаа дээр хуралдаж байгаа учраас гишүүд танхимдаа бүрэн дүүрэн сууж, асуудалдаа идэвхтэй оролцдог байх шаардлагыг тавина. Хэрвээ нэрээ өгчхөөд чуулганы танхимд 5 минутаас дээш хугацаанд байхгүй орхин гарсан тохиолдолд өгсөн нэрийг жагсаалтаас шууд хасдаг ийм зарчмаар ажлыг зохион байгуулна гэж үзэж байгаа.

Өнөөдөр Транс-Азийн төмөр замын гэрээг соёрхон батлах хуулийн төсөл бол Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонхын дэмжлэгийг аваагүй учраас хууль санаачлагчид буцаагдлаа. Цаашдаа бид аливаа байдал дээр хариуцлагатай хандах үүднээс энэ Улсын Их Хурлын гишүүдийн шүүмжилдэг, олон нийтийн шүүмжилдэг шүүмжлэлийн дагуу унасан саналыг босгохын тулд олон удаа горимын санал хураалгаж, асуудлыг авч явдаг энэ байдлыг таслан зогсооно. Аль, аль талдаа бүгдээрээ хариуцлагатай хандах үүднээс гишүүд энэ асуудал дээр зарчмын хувьд дэмжиж оролцсон бол асуудал шийдэгдээд явдаг энэ хэлбэр байна гэдгийг та бүхэндээ хэлэхийг хүсэж байна. Олон нийт Улсын Их Хурлаас энэ л зүйлийг хүсэж байгаа. Хэлэлцэж байгаа асуудал дээр хүн бүр анхааралтай, идэвхтэй, хариуцлагатай оролцож, ард иргэдийн амьдралд нийцсэн шийдвэрийг төр гаргаж өгөөч гэдэг зүйлийг биднээс хүсэж байгаа учраас бидний энэ зарчим амжилттай хэрэгжинэ гэдэгт огт эргэлзэхгүй байгаа.

Тэгээд Улсын Их Хурлын гишүүдэд ажлын амжилт хүсье. Баярлалаа. Өнөөдрийн чуулган хаалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА